

**МЭДЭЭ ТЭМДЭГЛЭЛ
ЯРИЛЦЛАГА****БҮХ ХЯТАДЫН АРДЫН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ИХ
ХУРЛЫН ДОЛОО ДАХЬ
УДААГИЙН СОНГУУЛИЙН
АНХДУГААР ЧУУЛГАНЫ
ТАЛААР**

Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал (БХАТИХ)-ын долоо дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган 1988 оны 3-р сарын 25 наас 4-р сарын 13-нд Бээжинд болов. Энэ удаагийн чуулганд оролцсон 2970 төлөөлөгчдийн 2107 нь шинээр сонгогдсон бөгөөд бүх төлөөлөгчдийн 71%-ийг эзэлжээ.

БХАТИХ-ын долоо дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганд Засгийн газрын ажлын тухай илтгэлийг БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч Ли Пэн, Улс ардын аж ахуй, нийгмийг 1988 онд хөгжүүлэх төлөвлөгөөний төслийн тухай илтгэлийг БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдын орлогч, Улсын төлөвлөгөөний Комиссын дарга Яо Илин; 1987 оны улсын төсвийн гүйцэтгэлийн байдал болон 1988 оны улсын төсвийн төслийн тухай илтгэлийг БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн гишүүн, Сангийн Яамны сайд Ван Еинцянь; БХАТИХ-ын Байнгын хорооны ажлын тухай илтгэлийг БХАТИХ-ын Байнгын Хорооны орлогч дарга Чэнь Писянь, Ардын дээд Шүүхийн ажлын тухай илтгэлийг БНХАУ-ын Ардын дээд Шүүхийн дарга Чжэн Тяньсян, Ардын дээд Прокурорын газрын ажлын тухай илтгэлийг БНХАУ-ын Ардын дээд Прокурорын газрын ерөнхий прокурор Ян Ичэнь нар тавив.

БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч Ли Пэн Засгийн газрын ажлын тухай илтгэлдээ өнгөрсөн таван жилийн ажилд хийсэн үндсэн дүгнэлт, ирэх таван жилд явуулах бүтээн байгуулалт болон шинэтгэлийн зорилт, чиглэл, гадаад харилцааны үйл ажиллагааны талаар яриу.

Тэр илтгэлдээ өнгөрсөн таван жилд шинэчлэл болон гадаадад нээлттэй байх бодлогыг хэрэгжүүлснээр хятадын улс ардын аж ахуй тасралтгүй хөгжиж, ерөнхий байдал сайн байгааг тэмдэглээд аж ахуйн систем дэх шинэчлэлийг хөдөө тосгон, хот суурин газарт бүх талаар өрнүүлэн, чухал их амжилт олж нэлээд их туршлага хуримтлагдсаны хамт шинжлэх ухаан-техник, соёл, боловсрол, улс төрийн зэрэг хүрээнд шинэчлэлийг шат дараалан явуулж үр дүнд хүрч байна гэжээ.

Ли Пэний илтгэлээс үзэхэд 1987 онд БНХАУ-ын үндэсний нийт бүтээгдэхүүний хэмжээ 1092 млрд., үндэсний орлого 915,3 млрд., санхүүгийн орлого 224,36 млрд. юаньд тус тус хүрч, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний хэмжээ 14.6%-иар, хөдөө тосгоны нийгмийн нийт бүтээгдэхүүний хэмжээ 12,7%-иар тус тус нэмэгдэн, 1987 онд үйлдвэрлэсэн үр тарианы хэмжээ 402,4 сая тонн болж, эдийн засгийн хөгжлийн ерөнхий байдал сайн байгаа боловч хятадын улс ардын аж ахуйг хөгжүүлэхэд бэрхшээл оршсон хэвээр байна. Энэ талаар Ли Пэн илтгэлдээ

өнгөрсөн таван жил бид олон талын ажилд асар их ололт амжилт олсон боловч урагшлах замд багагүй бэрхшээл, асуудал оршсон хэвээр байна. Эрчим хүч, тэгвэр харилцаа, шуудан холбоо, түүхий эдээр дутагдаж байгаагаас гадна санхүүгийн алдагдал ч нэлээд их байна гэж тэмдэглэжээ.

Ард түмний амьдралын түвшин цаашид дээшилж, тариачдын дундаж орлого 1982 онд 270 юань байсан бол 1987 онд 463 юань, хот суурин газрын оршин суугчдын дундаж орлого 1982 онд 494,5 юань байсан бол 1987 онд 916 юаньд хүрсэн гэж Ли Пэн илтгэлдээ тэмдэглэхийн зэрэгцээ хятадын эдийн засаг, нийгмийн амьдралд оршиж буй нэгэн онцгой асуудал бол барааны үнэ хэт их нэмэгдсэнээс болж ард түмний амьдралыг сайжруулахад зохих хэмжээгээр муу нөлөө үзүүлэн, хот суурин газрын зарим оршин суугчдын амьдралын түвшин буурсаныг дурдав.

Хятадын гадаад худалдааны талаар Ли Пэн ярихдаа өнгөрсөн хугацаанд гадаад худалдаа улам өргөжин, тухайлбал 1987 онд хятадын гадаад худалдааны нийт хэмжээ 82,7 млрд. ам. долларт хүрч, дунджаар жил бүр 14,7%-иар нэмэгдсэн байв. БНХАУ одоо дэлхийн 178 улс, районтой эдийн засаг, худалдааны харилцаатай байна гэв.

Ирэх таван жил явуулах бүтээн байгуулалт, шинэчлэлийн зорилт, чиглэлийн талаар БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч Ли Пэн хэлэхдээ ирэх таван жилд бидний зорилт бол шинэчлэлийг улам гүнзгийрүүлэн хурдацтай явуулж, улмаар үйлдвэрлэлийн хүчийг нэмэгдүүлэн таван жилийн төлөвлөгөөг биелүүлж, VI таван жилийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхэд орших бөгөөд 1982 он гэхэд үндэсний нийт бүтээгдэхүүний хэмжээг 1550 млрд. орчим юаньд хүргэнэ гэжээ.

Ли Пэн илтгэлийнхээ гадаад харилцааны үйл ажиллагааны тухай хэсэгт өнгөрсөн таван жилд хятадын дээд удирдах хүмүүс дэлхийн 46 улс орноор айлчилж, гадаадын 89 орны төрийн тэргүүн, Засгийн газрын удирдах хүмүүс хятадад айлчилсаныг тэмдэглээд 1983 оноос хойш БНХАУ дэлхийн 10 улс оронтой дипломат харилцаа шинээр тогтоон, одоо 135 оронтой дипломат харилцаатай байгааг дурдав.

Монгол-Хятадын харилцааг Ли Пэн «Хятад-монголын харилцаа хөгжсөн байна» гэсэн нэг өгүүлбэрээр дүгнэжээ.

Зөвлөлт-Хятадын харилцааны талаар Ли Пэн хэлэхдээ «Сүүлийн жилүүдэд Хятад, Зөвлөлт хоёр орны хоорондын худалдаа, шинжлэх ухаан техник болон ажилтан нарын солилцоо нэмэгдэв. Хятад, Зөвлөлтийн хоорондын төрийн харилцааг хэвийн болгох зөвлөлгөөн, хилийн хэлэлцээ явагдаж байна. Хятад-зөвлөлтийн харилцааг хэвийн болгох нь хоёр орны ард түмний хүсэл эрмэлзэл, үндсэн эрх ашигт нийцнэ» гэж тэмдэглэжээ.

Европын социалист орнуудтай БНХАУ сүүлийн жилүүдэд харилцаагаа ихээхэн хөгжүүлж байгаа бөгөөд Румын, Югославтай бүх талын найрсаг харилцаатай явж, Польш, БНАГУ, Чехословак, Унгар, Болгар зэрэг улстай харилцааг хэвийн болгов гэж Ли Пэн тэмдэглэв.

БХАТИХ-ын долоо дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганаар БНХАУ-ын даргаар Ян Шанкунь, орлогч даргаар Ван Чжэнийг; БХАТИХ-ын Байнгын хорооны даргаар Вань Ли, орлогч даргаар Си Чжунсюнь, Улаанхүү (монгол үндэстэн), Пэн Чун, Вэй Гоцин (чжуан үндэстэн), Чжу Сюефань, Нгапод-Агваанжигмэд (төвд үндэстэн), Ван-

чин-эрдэнэ Чойжижанцан (төвд үндэстэн), Сайфуддин-Ацзэцзы (уйгур үндэстэн), Чжоу Гучэн, Янь Цзицы, Жун Ижэнь, Е Фэй, Ляо Ханьшэн (туцзя үндэстэн), Ни Чжифу, Чэнь Мухуа, Фэй Сяотун, Сунь Цимэн, Лэй Цзецюн, Ван Ханьбинь нарыг сонгожээ.

Чуулганаар БНХАУ-ын Цэргийн Төв Зөвлөлийн даргаар Дэн Сяопиныг сонгож, ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Жао Зыян, БНХАУ-ын дарга Ян Канкунь нарыг орлогч даргаар, Хун Сюечжи, Лю Хуацин, Цинь Цзивэй, Чи Хаотянь, Ян Байбин, Чжао Наньци (солонгос үндэстэн) нарыг гишүүнээр баталжээ.

Чуулганаас Ли Пэнийг БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдаар, Яо Илин, Тянь Цзюнь, У Сюецянь нарыг ерөнхий сайдын орлогчоор, Ли Те-ин, Цинь Цзивэй, Ван Бинцян, Сун Цзянь, Ван Фан, Цзоу Цзяхуа, Ли Гуйсянь, Чэнь Ситун, Чэнь Цзюньшэн нарыг гишүүнээр томилжээ.

Чуулганаар Жэнь Цзяньсинийг БНХАУ-ын Ардын дээд Шүүхийн даргаар, Лю Фучжиг БНХАУ-ын Ардын дээд Прокурорын газрын ерөнхий прокуророор тус тус сонгов.

БХАТИХ-ын долоо дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганаас «БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн бүтцэд өөрчлөлт оруулах тухай төсөл», «БНХАУ-ын улс ардын аж ахуй, нийгмийг 1988 онд хөгжүүлэх төлөвлөгөө», «БНХАУ-ын Үндсэн хуульд оруулах засвар», «БНХАУ-ын нийт ард түмний өмчийн аж үйлдвэрийн газрын тухай хууль», «БНХАУ-аас гадаад оронтой хамтран эрхлэх аж ахуйн газрын тухай хууль», «БНХАУ-ын Аомыний онцгой засаг захиргааны районы Үндсэн хуулийн төслийг боловсруулах комиссыг байгуулах тухай шийдвэр», «Хайнань мужийг байгуулах тухай шийдвэр», «Хайнаний эдийн засгийн онцгой район байгуулах тухай тогтоол» болон бусад тогтоол шийдвэрийг баталжээ.

Н. Батаа